



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 14258

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Олон Улсын Хүүхдийн Найрамдал зусланд 2017 оны 07 дугаар сарын 27-ноос 08 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Ази, Номхон далайн бүсийн 31 дүгээр Жембори”-д оролцох аймгийн төлөөлөгчдөд аймгийн Засаг даргын дэмжлэг үзүүлэн хөрөнгө гаргасугай.

Хоёр. Хөрөнгө гаргах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх арга хэмжээнд шаардагдах 1841320 /Нэг сая найман зуун дөчин нэгэн мянга гурван зуун хорин / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200739